



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 4/182

Мандалговь

Г

Шагнах тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1.6, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Дундговь аймгийн Засаг даргын шагнал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 05 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өлзийт сумын харьяат Ёндон овогтой Нэргүй нь Дуу хуурийн өлгий нутгийнхаа урлаг соёлыг гадаад орнуудад сурталчилж, ардын урлагийг өсвөр залуу үедээ өвлүүлэн, хөгжүүлж байгаа хөдөлмөр бүтээлийг үнэлэн, аймгийн "Хүндэт дэвтэр"-т бичиж алдаршуулан, дурсгалын гэрчилгээ олгож, 150 000 /нэг зуун тавин мянган/ төгрөгөөр шагнасугай.

Хоёр. Дурсгалын гэрчилгээ хийлгэхэд болон дагалдах мөнгөн шагналд зарцуулах 185000 /нэг зуун наян таван мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200542